



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdtg@khentii.gov.mn

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ДАРГА С.МӨНХЦЭЦЭГ ТАНАА**

2022.04.06 № 7/740
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас дээд газраас ирүүлсэн тайлангийн маягтын дагуу тухайн үед нь гаргаж явуулдаг, бүртгэл байхгүй, хяналтад авдаггүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан заалт байхгүй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтот түвшнийг тодорхойлоогүй хоосон орхисон заалтууд байгаа бөгөөд суурь түвшин, хүрэх түвшинг бодлогын баримт бичигтэй уялдуулаагүй байгаа тул төлөвлөлтөө нягталж сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

2.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын Боловсрол, шинжлэх ухааны сайдтай байгуулсан гэрээний холбогдох зорилтуудыг мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж арга хэмжээ болгон нарийвчлан задалж хэрэгжүүлэх, хяналт тавих

3.Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 2.1 дэх заалтын дагуу

231060135

2.

мэргэжилтнүүд Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн багтаасан эсэхийг дахин нягтлах

4.Албан хаагчдын хувийн хэргийг нягтлан шалгаж дутуу баримт бичгийн бүрдлийг хангах, Төрийн жинхэнэ албанд орсон тухай нотлох баримт бичиг байхгүй 10 албан хаагчийн бичиг баримтыг бүрдүүлэх

5.Харилцаа хандлага, хувцаслалт, ажлын байрыг зөвшөөрөлгүй орхих, ажлаас хоцрох, үүрэг даалгаврын биелэлт зэрэг хяналтын хуудасны зөрчлийн үзүүлэлт дээр хяналт тавьж хяналтын хуудасны хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай. Угтах ажилтны харилцаа хандлагыг сайжруулж, байгууллагын стандартыг мөрдүүлэх

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 04 сарын 13-ны дотор ирүүлнэ үү..

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

